

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ХЭЛТЭС, АЛБАДЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 28

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ нь албан хаагчдын ажлын хариуцлага, сахилгыг бэхжүүлэх, бодлогын зорилтууд түүнийг хэрэгжилтийн үр дүн, цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлох, ажил үүргийн давхардал, доголдлыг арилгах, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, бүтээлч санаачилгыг өрнүүлэх, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Байгууллагын чиг үүргийн хэрэгжилт, Архивын улсын үзлэгийн дүн гэсэн 2 агуулгын хүрээнд 8 үндсэн үзүүлэлтээр дүүргийн төр захиргааны болон орон нутгийн өмчит нийт 30 байгууллага, 25 хорооны 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

ГУРАВ. АРГА ЗҮЙ

Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нарын бүрэлдэхүүнтэй үнэлгээний баг дүүргийн төр захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагуудын үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3-т заасан арга зүйгээр байгууллагуудын үйл ажиллагааны тайлант хугацааг 100 хувиар тооцож, үр дүнгийн ерөнхий үнэлгээг 0-100 хувиар үнэлсэн. Шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээний дундаж хувь нь:

85% буюу түүнээс дээш бол "Бүрэн хангалттай";

70-85% хүртэл "Хангалттай";

70% хүртэл "Хангалтгүй" гэж дүгнэсэн.

Шалгуур үзүүлэлтийн дагуу бэлтгэсэн бодлогын баримт бичгийн тайлан, мэдээ, байгууллагын үйл ажиллагааны үр дүн, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэл, төсвийн зарцуулалт, хэмнэлт, байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн болон шинээр санаачилсан бусад ажлууд, хүний нөөцийн удирдлагын ил тод байдал, тайлагналт, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, зөрчлийн тоо зэргийг нягтлан үзэж, цуглуулсан тайлан мэдээ, мэдээлэл, архивын улсын үзлэгийн дүн зэргийг үндэслэн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийн дүүргийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 33 дугаар хуралд танилцуулж, хэлэлцүүлэн дүүргийн Засаг даргын А/588 дугаар захирамжаар үнэлгээг баталсан.

ДӨРӨВ. ҮР ДҮН

1. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

1.1 Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт, гүйцэтгэлийн тайлан

Нийт байгууллагууд дүүргийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээ, гүйцэтгэлийн тайланг хугацаа хоцроож ирүүлэх, гэрээний биелэлтийг хангалтгүй, шаардлагатай тоон үзүүлэлт дутуу тусгах зэрэг нийтлэг дутагдал ажиглагдсан учраас бүрэн оноогоор үнэлэх боломжгүй байсан.

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;

№	Зорилт, арга хэмжээ		Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй 85%-аас дээш	Үр дүн хүлээгдэж байгаа 60-84	Үр дүн хангалтгүй 30-59	Үр дүн гараагүй 0-29	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	Үнэлгээ (хувь)
	Бүлэг									
1	Дүүргийн Засаг даргын эрх, үүрэг		9	104	97	3	4			96,0%
2	Нийслэлийн Засаг даргын дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт		1	5	3	1	1			86,3%
НИЙТ ДҮН			10	109	100	4	5			91,1%

Дүүргийн Засаг даргын 2025 оны хариуцлагын гэрээний 2 бүлэг 10 зорилт, 109 арга хэмжээ хагас жилийн байдлаар 53,8% үр дүн хангалтгүй байсан бол жилийн эцэст 91,1% үр дүнтэй хэрэгжсэн.

ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНЭЭС ХЭЛТЭС АЛБАДЫН ХАРИУЦСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

Хариуцсан хэрэгжүүлэх нэгжийн нэр		Гурав. Дүүргийн Засаг даргын эрх, үүрэг		Дөрөв. Нийслэлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт	
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Арга хэмжээ		12		1
	Хэрэгжилт (%)		96%		
Санхүү, төрийн сангийн хэлтэс	Арга хэмжээ		5		90%
	Хэрэгжилт (%)		89%		
Хууль, эрх зүйн хэлтэс	Арга хэмжээ		9		
	Хэрэгжилт (%)		100%		
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Арга хэмжээ		2		
	Хэрэгжилт (%)		100%		
Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс	Арга хэмжээ		4		85%
	Хэрэгжилт (%)		95%		
Нийгмийн хөгжлийн хэлтэс	Арга хэмжээ		27		
	Хэрэгжилт (%)		91%		
Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	Арга хэмжээ		26		
	Хэрэгжилт (%)		98%		
Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	Арга хэмжээ		6		
	Хэрэгжилт (%)		100%		
Онцгой байдлын хэлтэс	Арга хэмжээ		1		
	Хэрэгжилт (%)		100%		
Улсын бүртгэлийн хэлтэс	Арга хэмжээ		1		
	Хэрэгжилт (%)		100%		
Дотоод аудитын алба	Арга хэмжээ		2		
	Хэрэгжилт (%)		99%		
Худалдан авах ажиллагааны алба	Арга хэмжээ		4		
	Хэрэгжилт (%)		100%		
Газар зохион байгуулалтын алба	Арга хэмжээ		2		
	Хэрэгжилт (%)		100%		
Статистикийн хэлтэс	Арга хэмжээ		1		
	Хэрэгжилт (%)		100%		
Хан-Уул яармаг ОНӨААТҮГ	Арга хэмжээ		1		
	Хэрэгжилт (%)		100%		
Нийт хэлтсүүд	Арга хэмжээ		2		
	Хэрэгжилт (%)		100%		
Нийт арга хэмжээ			109		5
Хэрэгжилтийн дундаж хувь			91.1%		86%

[illegible]

Үзүүлэлт	Улсын их хурлын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж	Ерөнхий сайдын албан даалгавар	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын /ралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	НИТХ-ын тогтоол	Нийслэлийн Засаг даргын захирамж	НЗД-ын зөвлөлийн хурлын албан даалгавар	ДИТХ-ын тогтоол	Нийт
БИЕЛЭЛТИЙН ДҮН (хувь)	100%	100%	50%	98,4%	72%	100%	100%	100%	100%	96,9%	88,4%	91,4%

“Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд дүүрэг хамтран хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал;

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөөнөөс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх 2 бүлгийн 3 арга хэмжээ хагас жилийн байдлаар 63,3%, жилийн эцэст 97,5%-үр дүнтэй хэрэгжлээ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЧОО

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй (85+)	Үр дүн хүлээгдэж байгаа (60-84)	Үр дүн хангалтгүй (30-59)	Үр дүн гараагүй (0-29)	Биелэлт (хувь)
Нэг. Бүсчилсэн хөгжлийн бодлого	1	1	2	-	-	2	-	85%
Дөрөв. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	1	1	1	1	-	-	-	100%
Нийт	2	2	3	1	-	2	-	97,5%

Таван жилийн үндсэн чиглэлийн 1 бүлэг, 2 зорилт, 4 арга хэмжээ жилийн эцэст 100%, хяналт шинжилгээ, үнэлгээний 1 арга хэмжээ 100%-үр дүнтэй хэрэгжсэн.

МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛЭЭС ХАН-УУЛ ДҮҮРЭГ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОВЧОО

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй (100)	Тодорхой үр дүнд хүрсэн (70-100)	Эрчимжүүлэх шаардлагатай (30-70)	Үр дүнгүй (0-30)	Биелэлт (хувь)	Шалгуур үзүүлэлтэд тусгасан арга хэмжээ	Үнэлгээ (хувь)
Ес. Улаанбаатар ба дагуул хот	1	2	4	1	3	-	-	100%	1	100%

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 1 арга хэмжээ жилийн эцсийн байдлаар 100% үр дүнтэй хэрэгжиж, Засгийн газрын бодлогын баримт бичгийн тайлангуудыг 2025 оны 12 дугаар сарын 01-ний 04/1816 дугаар албан бичгээр 62 хуудас нотлох баримтын хамт нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэн рүү цахимаар илгээж, тайлагнасан.

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ХАН-УУЛ ДҮҮРЭГ
ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй (85+)	Үр дүн хүлээгдэж байгаа (60-84)	Үр дүн хангалтгүй (30-59)	Үр дүн гараагүй (0-29)	Биелэлт (хувь)
Хоёр. Бүсчилсэн хөгжлийн бодлого	1	1	1	1	-	-	-	100%

“Нийслэлийн Засаг даргын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал;

Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөөнөөс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх 4 бүлэг, 6 зорилго 14 зорилт, 23 арга хэмжээ хагас жилийн байдлаар 70%, жилийн эцэст 96%, Хяналт шинжилгээний 3 бүлгийн 17 шалгуур үзүүлэлт 93,8% үр дүнтэй хэрэгжжээ.

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЧОО**

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй (85%+)	Үр дүн хүлээгдэж байгаа (60-84)	Үр дүн хангалтгүй (30-59)	Үр дүн гараагүй (0-29)	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	Биелэлт (хувь)
Нэг. Бүсчилсэн хөгжлийн бодлого	2	5	8	2	1	-	-	1	93%
Хоёр. Хүний хөгжлийн бодлого	2	7	13	-	-	1	-	1	96,3%
Дөрөв. Ногоон хөгжлийн бодлого	1	1	1	-	-	-	-	-	100%
Тав. Засаглалын бодлого	1	1	1	1	-	-	-	-	100%

Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлээс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх 3 арга хэмжээ хагас жилийн байдлаар 78,3% хэрэгжиж үр дүн хүлээгдэж байсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 100% үр дүнтэй хэрэгжжээ.

**НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй (85+)	Үр дүн хүлээгдэж байгаа (60-84)	Үр дүн хангалтгүй (30-59)	Үр дүн гараагүй (0-29)	Биелэлт (хувь)	Шалгуур үзүүлэлтэд тусгасан арга хэмжээ	Үнэлгээ (хувь)
Ес. Улаанбаатар ба дагуул хот	3	3	3	1	3	-	-	100%	3	100%

Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнөөс Хан-Уул хамтран 4 бүлэг, 6 зорилго, 14 зорилтын хүрээнд 23 арга хэмжээ хагас жилийн байдлаар 54% үр дүн хангалтгүй байсан бол жилийн эцэст 91%, 2 бүлгийн 5 шалгуур үзүүлэлт 100%-үр дүнтэй хэрэгжсэн. Нийслэлийн

бодлогын баримт бичгийн тайлангуудыг 2025 оны 12 дугаар сарын 01-ний 04/1816 дугаар албан бичгээр 53 хуудас нотлох баримтын хамт нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэнд хугацаанд цахимаар илгээж, тайл агнасан.

**НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ХАН-УУЛ ДҮҮРЭГ
ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй (85%+)	Үр дүн хүлээгдэж байгаа (60-84)	Үр дүн хангалтгүй (30-59)	Үр дүн гараагүй (0-29)	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	Биелэлт (хувь)
Нэг. Бүсчилсэн хөгжлийн бодлого	2	5	8	2	1	-	-	1	93%
Хоёр. Хүний хөгжлийн бодлого	2	7	13	-	-	1	-	1	96,3%
Дөрөв. Ногоон хөгжлийн бодлого	1	1	1	-	-	-	-	-	100%
Тав. Засаглалын бодлого	1	1	1	1	-	-	-	-	100%

Дүүргийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал;

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3 бүлэг, 15 зорилго, 90 зорилтын хүрээнд 136 арга хэмжээ 90,8%, үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 94 шалгуур үзүүлэлт 88,2% үр дүнтэй хэрэгжсэн. Биелэлтийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, 2025 оны 15 тогтоолоор "Хангалттай" үнэлэгдсэн.


№	Агуулга	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Бүрэн хангалттай (85буюу түүнээс дээш)	Хангалттай (70-85 хүртэл)	Хангалтгүй (70 хүртэл)	Хугацаа болоогүй	Биелэлт
1	Төрийн албаны зохион байгуулалт-20 минутын хотын шилжилт	3	20	38	32	3	3		92.6%
2	Эко дүүрэг-Ногоон хөгжил	9	54	78	57	7	11	3	88.1%
3	Дэд бүтэц-Хот нийтийн аж ахуй	3	16	20	15	2	2	1	91.6%
	НИЙТ ДҮН	15	90	136	104	12	16	4	90.8%

1.4 Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал

Дүүргийн хэмжээнд өмнөх оны мөн үед 6390 өргөдөл бүртгэгдэж байсан бол энэ онд 6156 болж, 2,7 хувь, гомдол 2462 байсан бол энэ онд 2043 гомдол бүртгэгдэж 17.0 хувь,


хугацаа хэтэрсэн шийдвэрлэлт 22-оос 2 буюу 90,9 хувь, шийдвэрлэх явцын зөрчил 649-өөс 488 хүртэл 24,8 хувиар тус тус буурчээ.

ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН ХАРЬЦУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТ



Дөрөвдүгээр улиралд бүртгэгдсэн гомдлоос Засаг даргын Тамгын газарт 28%, Боловсролын хэлтэст 19%, Цагдаагийн газарт 14%, Газар зохион байгуулалтын алба, Хороод тус бүр 10%, Эрүүл мэндийн төв 7%, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, бусад хэлтэс алба ОНӨААТҮГ тус бүр 4%, Нэгдсэн эмнэлэг 2%, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын газар тус бүр 1% нь бүртгэгджээ.

ХАН-УУЛ ДҮҮРЭГТ 2025 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРАЛД БҮРТГЭГДСЭН ГОМДЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, БАЙГУУЛЛАГА, НЭГЖЭЭР



№	Улирал	1 дүгээр улирал		2 дугаар улирал		3 дугаар улирал		4 дүгээр улирал		Нийт	
		2024 он	2025 он	2024 он	2025 он	2024 он	2025 он	2024 он	2025 он	2024 он	2025 он
	Хэлтэс, албадын нэр										
1	Засаг даргын Тамгын газар	132	61	182	152	129	94	113	112	556	419
2	Хороод	44	24	38	56	108	67	33	42	223	189
3	Цагдаагийн газар	34	55	70	85	99	94	64	56	267	290
4	Татварын хэлтэс	8	11	5	8	8	4	6	3	27	26
5	Улсын бүртгэлийн хэлтэс	10	7	13	12	25	7	10	0	58	26
6	Нийгмийн даатгалын газар	28	27	79	6	109	13	71	5	287	51
7	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс	22	10	37	21	16	15	23	14	98	60
8	Боловсролын хэлтэс	31	33	27	53	119	224	113	77	290	387
9	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс	0	0	3	3	1	2	3	2	7	7
10	Эрүүл мэндийн төв	32	27	61	46	63	31	65	26	221	130
11	Нэгдсэн эмнэлэг	7	13	26	14	30	17	15	7	78	51
12	Газар зохион байгуулалтын алба	27	39	90	146	75	69	85	41	277	295
13	Онцгой байдлын хэлтэс	1	9	4	8	3	0		1	8	18
14	ОНӨААТҮГ	5	8	10	37	30	25	18	15	63	85
15	Бусад нэгж	0	8	1	0	1	0		1	2	9
	Нийт	381	332	646	647	816	662	619	402	2462	2043

Ирүүлсэн гомдлын 2,9 хувийг нэр бүхий албан хаагчийн ёс зүй, зан харилцааны талаарх гомдол, 50,7 хувийг төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, зохицуулалт, 46,3 хувь нь хот, нийтийн аж, ахуй, худалдаа, үйлчилгээ, явган болон авто замын орц, гарц, орчны эрүүл, аюулгүй байдал зэрэг бусад асуудлууд эзэлж байгаа юм.



Өмнөх оны мөн үетэй харьцуулбал Засаг даргын Тамгын газар, Хороод, Эрүүл мэндийн төв, Татварын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Тохижилт, үйлчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, Улсын бүртгэлийн хэлтэст бүртгэгдсэн гомдлын тоо буурсан хэдий ч Боловсролын хэлтэс, Цагдаагийн газар, Газар зохион

байгуулалтын алба зэрэг бусад хэлтэс алба, зарим ОНӨААТҮГазрын гомдлын тоо өссөн байна.

Зарим хэлтэс, байгууллагад нэг агуулгатай гомдол удаа дараа бүртгэгдэж байгаа нь асуудлыг шийдвэрлэж, таслан зогсоохгүй хугацаа алдаж, дахин гомдол гарах нөхцөл бүрдсээр байгаагийн илрэл юм.


Тухайлбал Цагдаагийн газарт хэргийг илрүүлэх талаар өгсөн иргэдийн гомдол нь албан хаагчид хадгалагдан хэдэн жил дамнан шийдэгдэхгүй алсарч, иргэд өмч, хөрөнгө, эрүүл мэнд, сэтгэл зүйгээр хохирсоор, хохирол нэмэгдсээр гомдол нь эцэслэхгүй ужгирч даамжирсаар байна.

ХАН-УУЛ ДҮҮРЭГТ 2024, 2025 ОНД БҮРТГЭГДСЭН ГОМДЛЫН ТОО




4 дүгээр улиралд бүртгэгдсэн гомдлын ерөнхий агуулга;


НЭР БҮХИЙ АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙ, ХАРИЛЦАА, ХАНДЛАГА, АЖЛЫН ХАРИУЦЛАГЫН ТАЛААР



БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР



БУСАД АСУУДЛААР




Өмнөх оны дөрөвдүгээр улиралд бүртгэгдсэн 619 гомдлын 59,8 хувийг иргэний талд шийдвэрлэж, 27,6 хувьд нь боломжгүй хариу өгч, 5,9 хувийг бусад хэлбэрээр шийдвэрлэн 6,4 хувь нь судлгааны шатанд байсан бол энэ оны дөрөвдүгээр улиралд бүртгэгдсэн 402 гомдлын 56,9 хувийг иргэний талд шийдвэрлэж, 36,6 хувьд нь боломжгүй хариу өгч, 6,4 хувийг судалж байна.

ХАН-УУЛ ДҮҮРЭГТ 2024, 2025 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР УЛИРАЛД БҮРТГЭГДСЭН ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ



Засаг даргын Тамгын газарт 2025 оны дөрөвдүгээр улиралд бүртгэгдсэн гомдлыг хэлтсүүдэд хуваарилагдсан байдлаар нь үзвэл;



Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн 110 гомдлын 44 хувь нь Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс, 40 хувь нь Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст, 10 хувь нь Төрийн захиргааны удирдлагын хэлтэст, Хууль, эрх зүйн хэлтэс, Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэст тус бүр 2 хувь, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэст тус бүр 1 хувь нь тус тус бүртгэгджээ.

Гомдлын агуулга, шийдвэрлэлт:

Хэлтэс, албадын нэр	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Хууль, эрх зүйн хэлтэс	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	Нийгмийн хөгжлийн хэлтэс	Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс	Цэргийн штаб	Нийт
Огноо	2025 он	2025 он	2025 он	2025 он	2025 он	2025 он	2025 он	2025 он	2025 он
ЗДТГ болон хорооны албан хаагчийн ёс зүйтэй холбоотой	4								4
Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаатай холбоотой	7				3	1			11
СӨХ, орон сууцны дээвэртэй холбоотой				17					17
Цахилгаан, эрчим хүч, гэрэлтүүлэгтэй холбоотой				3			1		4
Хог орчны бохирдол				2	1				3
Явган зам, Халтиргаа, гулгаа				9					9
Авто зогсоол, тохижилттой холбоотой асуудлаар				5	2				7
Дэд бүтэц, авто зам, гүүрэн байгууламж				3			1		4
ТҮЦ, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар					36				36
Бусад асуудлаар		1	2	9	2			1	15
Иргэний талд шийдсэн	9	1	1	21	20	1			53
Судалж байгаа	2			1	4		1		8
Бусад									0
Боломжгүй хариу өгсөн			1	26	20		1	1	49
Нийт	11	1	2	48	44	1	2	1	110

Үүнээс үзэхэд нийт гомдлын 15,4% нь Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаатай холбоотой гомдол, хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээтэй холбоотой гомдлууд, 71,0% нь дэд бүтэц, хот нийтийн аж ахуйн чиг үүрэгтэй холбоотой бусад гомдлууд, албан хаагчийн ёс зүй, ажлын хариуцлагатай холбоотой гомдол 3,6%, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол 10,0%-ийг тус тус эзэлж байгаа юм.

Гомдлын агуулга	Албан хаагчийн ёс зүй	Нохой, муур	Орчны бохирдол	Эзэнгүй адуу мал	Авто зам, зогсоол	СӨХ-ийн талаар	Халтиргаа, Гулгаа	Явган зам, орц, гарц	Гэрэлтүүлэг	Бусад асуудлаар	Нийт	Иргэний талд	Боломжгүй	Бусад	Судалж байгаа	Нийт
Хороод																
1 дүгээр хороо	1							1		1	3	1	2	1		3
2 дугаар хороо	1									1	2	1	1			2
3 дугаар хороо									1		1	1				1
4 дүгээр хороо								1			1	1				1
5 дугаар хороо											0					0
6 дугаар хороо		1									1	1				1
7 дугаар хороо											0					0
8 дугаар хороо										1	1	1				1
9 дүгээр хороо					1						1	1				1
10 дугаар хороо		1									1	1				1
11 дүгээр хороо			1		1					1	3	3				3
12 дугаар хороо			1							1	2	2				2
13 дугаар хороо											0					0
14 дүгээр хороо	2		1		1					1	5	4	1			5
15 дугаар хороо			1			1				1	3	3				3
16 дугаар хороо										2	2	2				2
17 дугаар хороо										1	1	1				1
18 дугаар хороо					1					1	2	2				2
19 дүгээр хороо					1					2	3	2	1		1	3
20 дугаар хороо									1		1	1				1
21 дүгээр хороо					1	1		1		1	4	1	3			4
22 дугаар хороо		1									1	1			1	1
23 дугаар хороо						1		1		1	3	1	2			3
24 дүгээр хороо						1					1	1				1
25 дугаар хороо											0					0
Нийт	4	3	4	0	6	4	0	4	2	15	42	32	10	0	0	42

Хороодод бүртгэгдсэн гомдлын 19,0 хувь нь хог тээвэрлэлт, орчны бохирдол, явган зам, орц, гарцны талаар 14,3 хувь авто зам, зогсоолын талаар, 4,8 хувь нь гэрэлтүүлэг, 35,7 хувь нь бусад асуудлаар, 7,1% хувь нь эзэнгүй нохой муурны талаар гомдол, сууц өмчлөгчдийн холбоодын талаар гаргасан гомдол, нэр бүхий албан хаагчийн талаар гомдол, гомдлууд тус бүр 9,5 хувь эзэлж байна.

2.АРХИВЫН УЛСЫН ҮЗЛЭГ

2.1 Төрийн ажлын зохион байгуулалт

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтыг 4 үндсэн үзүүлэлт, 44 шалгуурын дагуу 120 оноогоор үнэлсэн.Үүнд:

2.1.1. Байгууллагын удирдлага, зохион байгуулалт

Нийт байгууллагууд Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн баримт бичиг, салбар, орон нутгийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг журмын дагуу боловсруулж хуульд заасан хугацаанд, төлөвлөлтөд нийцүүлэн үр дүнг тооцож, тайлагнажээ. Мөн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад холбогдох журмын дагуу улирал тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн зохих урамшууллыг олгож хэвшсэн байна.

2.1.2. Байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа

Байгууллагууд албан хаагчдын сургалтын хэрэгцээнд үндэслэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулдаг ч зарим байгууллагад энэ чиглэлийн үйл ажиллагаа хангалтгүй байсан.

Хүний нөөцийн томилгоо, чөлөөлөлт, нөөц бүрдүүлэлттэй холбоотой зөрчил байхгүй, ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа тогтмолжсон, мэдээ, тайланг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж хэвшсэн.

Албан хаагчдын цалин хөлс, зэрэг дэв, бусад нэмэгдлийг холбогдох журмын дагуу үнэн зөв тогтоон үйл ажиллагааны үр дүнгээр урамшуулал олгох ажил хэвийн явагдаж байна.

Нийт байгууллагууд ажилтан албан хаагчдаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулж хэвшсэн нь сайшаалтай.

2.1.3. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөн

Төрийн захиргааны байгууллагууд албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний болон бусад мэдээллийг бүрэн оруулж, тайлант хугацаанд холбогдох дээд шатны байгууллагад тайлагнаж хэвшсэн байна.

Дүүргийн орон нутгийн өмчит газрууд Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн цахим систем ашигладаггүй бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бүтэц орон тооны хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Хороодын албан хаагчдын хувьд Засаг даргын Тамгын газрын Хүний нөөц, хөрөнгө, орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн Хүний нөөцийн удирдлагын цахим системд холбогдох мэдээллийг тухай бүр шинэчлэн баяжилт хийж, харьяа дээд шатны байгууллагад товчлон хугацаанд тайлагнан ажилладаг.

2.1.4. Хүний нөөцийн сонгон шалгаруулалт, шатлан дэвшүүлэх үйл ажиллагаа

Нийт байгууллагууд Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын дагуу албан хаагчдын хувийн хэргийг бүрэн бүрдүүлж, тухай бүр баяжилт хийгдсэн.

Нутгийн захиргааны байгууллагын анхан шатны нэгж буюу хорооны төрийн албан хаагчдын хүний нөөц бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтыг Засаг даргын Тамгын газраас холбогдох журмын дагуу зохион байгуулж, бүрдүүлдэг бөгөөд зөрчилгүй, харьцангуй тогтвор суурьшилтай ажиллаж байна.

2.2 Байгууллагын архивын үйл ажиллагаа

Байгууллагын архивын үйл ажиллагааг 9 үндсэн үзүүлэлт, 38 шалгуурын хүрээнд 1000 оноогоор үнэлж дүгнэсэн. Нийт байгууллагууд дотооддоо ажлын хэсэг байгуулж, улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангаж, урьдчилсан үзлэгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан.

Архивын өрөөнд шаардлагатай тавиур шүүгээг шинэчлэн сайжруулж, архивын баримтын стандарт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр төсөв, хөрөнгө зарцуулж, шаардлагатай техник хэрэгсэл, ном гарын авлагаар хангаж ач холбогдол өгч ажилласан нь сайшаалтай.

Үзлэгээр дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн.Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагааны явцад үүсэж хөтлөгдсөн тусгай төрлийн баримт (кино, гэрэл зураг, дүрс бичлэг, дуу авиа гэх мэт)-ыг архивд нөхөн бүрдүүлж аваагүй, бүртгэл хөтлөөгүй,
- Түүхчилсэн лавлахыг тухай бүр баяжуулаагүй,
- БНШК-ын төлөвлөгөө, тайлан дутуу,
- Архивын ажилтан солигдоход тооллого үйлдээгүй,
- Ажилтан ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд Нийслэлийн Засаг даргын 2015 оны Захирамжаар батлагдсан А/633 актаар хүлээлцдэггүй,
- Зөвшөөрөлгүй дамжих аливаа хандалтуудыг хязгаарлаагүй,
- Дотоодод архивын баримт ашиглуулсан бүртгэлийг журмын дагуу хөтөлж хэвшээгүй,
- 2019 оны Улсын үзлэгийн болон урьдчилсан үзлэг шалгалтын тайлан, мэдээлэл байхгүй гэх зэрэг алдаа дутагдалтай ажилласан байна.

2.3 Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа

Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа 10 үндсэн үзүүлэлт 38 шалгуур үзүүлэлт 1000 оноогоор үнэлж дүгнэсэн.

• Нийтлэг ололттой тал:

Байгууллагын удирдлагын зүгээс байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтныг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангасан, хүний нөөцийг чадавхжуулах ажлыг зохион байгуулсан.

Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд албан хэрэг хөтлөлт, албан бичгийн шийдвэрлэлтийн талаар хүлээх үүргийг тусгасан.

Албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтны цалин хөлс, урамшуулал зэргийг холбогдох журмын дагуу олгож хэвшсэн.

Захирамжлалын баримт бичгийг байгууллагын архивын "Archive eDog" системд цахим нөхөн баяжилт хийсэн.

Байгууллага бүр дотооддоо ажлын хэсэг байгуулж, үзлэгийн бэлтгэл ажлыг хангаж, урьдчилсан үзлэгээр өгсөн заавар зөвлөгөөг биелүүлж ажилласан байлаа.

Байгууллагын албан хэрэг хөтлөлт, түүний зохицуулалтын талаар мөрдөж ажиллах дүрэм журмыг баталсан.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд болон бага сургуулийн байгууллагын жишиг бүтэц орон тоог баталж өгөөгүй дутагдалтай талыг дотоод нөөц боломжийг ашиглан төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хэвийн явуулж байна.

• Нийтлэг зөрчил дутагдал

Зохион байгуулалтын нэгж, ажилтнуудаас албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилт хангалтгүй. Ялангуяа хэвлэмэл хуудас ашиглахад индекс, файлын санамж хэрэглэх талаар хангалтгүй.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар хангалтгүй компьютерын болон,"e doc" системийн нууц үгийн ашиглалт стандартын дагуу ашигладаггүй, Ажилтан ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд үүссэн баримт бичгийг Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/633 дугаар захирамжийн хавсралтын дагуу актаар хүлээлцдэггүй,

Ажил хүлээлцэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд архив, бичиг хэргийн ажилтныг оролцуулдаггүй,


Захирамжлалын болон мэдээлэл лавлагаа, зохион байгуулалтын баримт бичгийн зохион бүрдүүлэхэд тавигдах шаардлага дутуу, тушаал, захирамж, төлөвлөгөө, тайлан, илтгэх хуудас, дүрэм журам боловсруулж байгаа албан хаагчид Баримт бичгийн MNS 5140-2120 стандартад заасан бүрдлийг хангаагүй, монгол хэлний зөв бичгийн дүрмийн болон найруулгын алдаатай боловсруулсан зэрэг зөрчил дутагдал илэрсэн.

Байгууллагын онцлогт тохирсон албан хэрэг хөтлөлтийн журмыг ихэнх байгууллага 2025 онд батлан гаргасан байна.

Ихэнх байгууллага дээр Дээд газрын тогтоол шийдвэрийн бүртгэл, шийдвэрлэлтийн талаар тусгайлан бүртгэл хөтөлж, тайлагнаагүй зэрэг дутагдал үзлэгт хамрагдсан байгууллагуудад нийтлэг байлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 214 дүгээр тушаалаар батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтын дагуу 2025 онд дүүрэгт ирсэн албан бичгийн мэдээ, тайланд хяналт-шинжилгээ хийсэн.

ХАН-УУЛ ДҮҮРЭГТ 2024, 2025 ОНД ИРСЭН АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ



2025 ОНД ИРСЭН АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ



Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж хаасан 108 бичгийн 37% нь хороод, 29% нь дэргэдэх хэлтэс албадад, 19% нь Засаг даргын Тамгын газарт, 14% нь сургууль, цэцэрлэгүүдэд, 1% нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд бүртгэгдсэн.

Нийслэлийн төр захиргааны байгууллагуудад ашиглаж буй edoc программаас гарсан 2025 оны тайланд тус дүүргийн албан бичгийн индекс 0.72 буюу В үнэлэгджээ.

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн албан бичиг	Хариутай бичгийн тоо	Шийдвэрлэлт				Хариугүй бичгийн тоо	Хаалт				Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор)
				Хугацаандаа шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	Судалж байгаа	Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь		Хугацаандаа хаасан	Хугацаа хэтэрч хаасан	Судалж байгаа	Хариугүй бичгийн хаалтын хувь		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1	Ахмадын хороо	104	18	16	2	0	94.44	86	85	1	0	99.42	95.44	2.88
2	Биеийн тамир, спортын хороо	197	34	33	0	1	100	163	162	0	1	100	100	2.7
3	Боловсролын хэлтэс	1880	108	107	0	1	100	1772	1767	2	3	99.94	99.99	1.13
4	Газар зохион байгуулалтын алба	2789	281	269	4	8	99.27	2508	2503	0	5	100	99.42	2.54
5	Дотоод аудитын алба	146	26	23	3	0	94.23	120	117	0	3	100	95.38	2.86
6	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв	157	22	22	0	0	100	135	135	0	0	100	100	2.01
7	Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ	324	28	28	0	0	100	296	294	1	1	99.83	99.97	2.86
8	Насан туршийн суралцахуйн төв	238	13	13	0	0	100	225	222	0	3	100	100	1.47
9	Нийгмийн даатгалын газар	2280	118	118	0	0	100	2162	2109	0	53	100	100	4.71
10	Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ	302	25	25	0	0	100	277	276	0	1	100	100	4.8

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
11	Нэгдсэн эмнэлэг	461	33	33	0	0	100	428	421	0	7	100	100	4.18
12	Онцгой байдлын хэлтэс	785	72	70	0	2	100	713	705	1	7	99.93	99.99	4.91
13	Онцгой комисс	32	0	0	0	0	100	32	32	0	0	100	100	7.69
14	Соёлын ордон	239	26	25	0	1	100	213	210	0	3	100	100	2.91
15	Статистикийн хэлтэс	128	13	13	0	0	100	115	114	0	1	100	100	3.31
16	Татварын хэлтэс	1985	1397	1355	3	39	99.89	588	587	0	1	100	99.91	5.46
17	Тохижилт Үйлчилгээний төв ОНӨААТҮГ	257	29	27	2	0	96.55	228	227	0	1	100	97.24	2.84
18	Усан спорт сургалтын төв ОНӨУТҮГ	122	18	17	1	0	97.22	104	104	0	0	100	97.78	1.4
19	Хан Эко тээвэр ААТҮГ	178	17	17	0	0	100	161	159	0	2	100	100	3.2
20	Хан-Уул Агро ОНӨААТҮГ	160	23	22	1	0	97.83	137	137	0	0	100	98.26	3.09
21	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс	885	116	115	1	0	99.57	769	765	3	1	99.8	99.62	2.34
22	Худалдан авах ажиллагааны алба	368	29	28	1	0	98.28	339	339	0	0	100	98.62	2.82
23	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс	858	177	172	3	2	99.14	681	676	0	5	100	99.31	3.01
24	Эко ахмадын сувилал	91	16	13	2	1	93.33	75	74	0	1	100	94.66	3.71
25	Эко хотын тээвэр ОНӨААТҮГ	178	20	20	0	0	100	158	158	0	0	100	100	2.29
26	Эрүүл мэндийн төв	789	49	48	0	1	100	740	738	0	2	100	100	1.81
27	Яармаг ОНӨААТҮГазар	194	14	14	0	0	100	180	180	0	0	100	100	2.9
Нийт		16127	2722	2643	23	56	99.57	13405	13296	8	101	99.97	99.65	3.26

Хороодод 2025 онд ирсэн албан бичгийн шийдвэрлэлт:

Байгууллагын нэр	Энэ хугацаанд ирсэн бичгийн тоо	Үүнээс хариутай бичгийн тоо	Шийдвэрлэлт				Үүнээс хариугүй бичгийн тоо	Хаалтын байдал				Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь	Шийдвэрлэлтийн хугацаа (хоногоор)
			Хугацаандаа шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	Судалж байгаа	Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь		Хугацаандаа хаасан	Хугацаа хэтэрч хаасан	Судалж байгаа	Хариугүй бичгийн хаалтын хувь		
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1 дүгээр хороо	292	58	57	1	0	99.14	234	233	0	1	100	99.31	2.83


0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
10 дугаар хороо	319	50	49	1	0	99	269	269	0	0	100	99.2	2.3
11 дүгээр хороо	325	57	54	2	1	98.21	268	266	0	2	100	98.57	0.63
12 дугаар хороо	296	49	47	2	0	97.96	247	244	1	2	99.8	98.33	3.85
13 дугаар хороо	318	50	48	2	0	98	268	268	0	0	100	98.4	4.68
14 дүгээр хороо	314	51	50	1	0	99.02	263	261	0	2	100	99.22	2.11
15 дугаар хороо	378	77	76	1	0	99.35	301	300	1	0	99.83	99.45	1.75
16 дугаар хороо	308	44	42	2	0	97.73	264	263	1	0	99.81	98.15	1.29
17 дугаар хороо	313	62	58	2	2	98.33	251	248	0	3	100	98.66	4.81
18 дугаар хороо	285	46	45	1	0	98.91	239	239	0	0	100	99.13	1.98
19 дүгээр хороо	300	59	58	1	0	99.15	241	240	0	1	100	99.32	2.06
2 дугаар хороо	288	52	50	2	0	98.08	236	235	0	1	100	98.46	1.65
20 дугаар хороо	311	51	50	1	0	99.02	260	260	0	0	100	99.22	0.97
21 дүгээр хороо	363	52	51	1	0	99.04	311	310	0	1	100	99.23	2.89
22 дугаар хороо	300	44	43	1	0	98.86	256	256	0	0	100	99.09	1.91
23 дугаар хороо	351	54	52	2	0	98.15	297	297	0	0	100	98.52	2.81
24 дүгээр хороо	305	50	49	1	0	99	255	254	0	1	100	99.2	0.63
25 дугаар хороо	293	44	42	2	0	97.73	249	249	0	0	100	98.18	4.6
3 дугаар хороо	334	70	69	1	0	99.29	264	262	0	2	100	99.43	2.38
4 дүгээр хороо	307	47	46	1	0	98.94	260	259	1	0	99.81	99.11	4.33
5 дугаар хороо	276	43	41	2	0	97.67	233	233	0	0	100	98.14	3.27
6 дугаар хороо	284	117	116	1	0	99.57	167	166	0	1	100	99.66	2.99
7 дугаар хороо	283	43	42	1	0	98.84	240	239	0	1	100	99.07	3.58
8 дугаар хороо	316	49	47	2	0	97.96	267	266	0	1	100	98.37	3.55
9 дүгээр хороо	292	125	123	2	0	99.2	167	167	0	0	100	99.36	2.88
Нийт	7751	1444	1405	36	3	98.75	6307	6284	4	19	99.97	98.99	2.65

Тайлант хугацаанд дүүргийн хэмжээнд нийт 705 зөрчил бүртгэгдсэн бөгөөд үүний 34,6 хувь нь дэргэдэх хэлтэс, албадад, 22,6 хувь нь хороодод, 17,2 хувь нь ерөнхий боловсролын сургуулиуд, 12,3 хувь нь цэцэрлэгүүд, 7,8 хувь нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, 5,5 хувь нь Засаг даргын Тамгын газарт тус тус бүртгэгджээ. Албан бичгийн зөрчил 2024 оны мөн үетэй харьцуулахад 52,1 хувиар буурсан бөгөөд өмнөх жилүүдээс эрс буурч байгаа нь сайшаалтай ч нийт 705 зөрчлийн 44,3 хувь нь тэргүү бүрдэл оновчтой бус, байгууллагын нэр буруу зэрэг стандартын зөрчил, 12 хувь нь буруу шилжүүлсэн, хавсралт файл алдаатай зэрэг систем ашиглалтын зөрчил, 12,7 хувь нь шийдвэрлэх хугацааны, 30,9 хувь нь албан бичиг шийдвэрлэлтийн зөрчлүүд тус тус эзэлжээ. Тухайлбал хороодод бүртгэгдсэн 159 зөрчлийн 34 нь байгууллагын нэр буруу бичсэн, 6 нь тэргүү буруу бичсэн, үлдсэн нь стандартын бусад

зөрчлүүд байгаа бол дэргэдэх байгууллагуудад бүртгэгдсэн 244 зөрчлийн 116 нь стандартын, 75 нь шийдвэрлэлтийн 30 нь шийдвэрлэх хугацааны, 23 нь систем ашиглалтын зөрчил байна.

Дүүргийн хэмжээнд албан бичиг шийдвэрлэлтийн болон стандартын зөрчилгүй ажиллах боломжтой ч эдгээр зөрчлүүд нь албан бичгийн шийдвэрлэлтийн индексийг бууруулах гол хүчин зүйл болж, өмнөх улирлын дүнгээс төдийлөн ахиц гарахгүй байсаар байна.

АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТЭД ЭЗЛЭХ ЗӨРЧЛИЙН ХУВЬ




ХАН-УУЛ ДҮҮРЭГТ 2025 ОНД БҮРТГЭГДСЭН ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ

2025 оны 12 дугаар сарын 26 09:17							Улаанбаатар хот					
Байгууллагын нэр	Нийт зөрчлийн тоо	Жилийн нийт зөрчил					А. Стандартын зөрчил			Б. Систем ашиглалтын зөрчил		
		Стандартын зөрчил	Систем ашиглалтын зөрчил	Шийдвэрлэх хугацааны зөрчил (автомат ажилбар)	Албан бичгийн шийдвэрлэлтийн зөрчил	Сонгосон хугацааны нийт зөрчлийн тоо	Тэргүү бүрдэл оновчтой бус	Байгууллагын нэр буруу бичсэн	Бусад стандартын зөрчил	Байгууллагад буруу шилжүүлсэн	Хавсарлт файл алдаатай, буруу	Бусад систем ашиглалтын зөрчил
Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	55	19	16	7	13	55	1	3	15	1	2	13
Засаг даргын Тамгын газар	39	6	2	6	25	39	0	4	2	0	0	2

Байгууллагын нэр	Нийт зөрчлийн тоо	Жилийн нийт зөрчил					Сонгосон хугацааны нийт зөрчлийн тоо	А. Стандартын зөрчил			Б. Систем ашиглалтын зөрчил		
		Стандартын зөрчил	Систем ашиглалтын зөрчил	Шийдвэрлэх хугацааны зөрчил (автомат ажилбар)	Албан бичгийн шийдвэрлэлтийн зөрчил	Тэргүү бүрдэл оновчтой бус		Байгууллагын нэр буруу бичсэн	Бусад стандартын зөрчил	Байгууллагад буруу шилжүүлсэн	Хавсарлт файл алдаатай, буруу	Бусад систем ашиглалтын зөрчил	
Хороод	159	80	23	24	32	159	6	34	40	5	11	7	
Дэргэдэх байгууллагууд	244	116	23	30	75	244	9	40	67	6	8	9	
Сургууль	121	39	8	15	59	121	0	12	27	2	0	6	
Цэцэрлэг	87	52	13	8	14	87	2	24	26	7	1	5	
Нийт	705	312	85	90	218	705	18	117	177	21	22	42	

Монгол Улсын Засгийн газрын Шил ажиллагаа-<https://shilen.gov.mn/index> цахим хуудасны 3 дугаар улирлын үнэлгээг харуулбал:



Улсын бүртгэлийн хэлтэс-14, Татварын хэлтэс-14, Боловсролын хэлтэс-5, Газар зохион байгуулалтын алба-8, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс-2, Дотоод аудит алба-1,

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс И-Халамж-69, Худалдан авах ажиллагааны алба-1, Нийгмийн даатгалын газар-13 төрлийн даатгалын үйлчилгээ, Нэгдсэн эмнэлэг-2, Эрүүл мэндийн төв-2, Биеийн тамир, спортын хороо-10, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв-2, Усан спорт, сургалтын төв ОНӨУТҮГ-4, Зам засвар арчлалт ОНӨААТҮГ-2, Тохижилт, үйлчилгээний төв ОНӨААТҮГ-2, Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-6 үйлчилгээний мэдээлэл, бүрдүүлэх баримтын жагсаалт, төлбөр хураамжийн жагсаалтыг дүүргийн цахим хуудсанд байршуулсан.

ТАВ. ДҮГНЭЛТ

Дүүргийн Засаг даргын дэргэдэх 20 хэлтэс албад, 10 орон нутгийн өмчит газар, 23 хороод 70-85% хүртэл буюу "Хангалттай" үнэлэгдэж, 4, 12 дугаар хороод 75% хүртэл буюу "Хангалтгүй" үнэлэгдсэн.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

1. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4, 7 дугаар хавсралтын дагуу тус тус боловсруулж хугацаанд нь тайлагнаж хэвших,

2. Бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, үүрэг даалгаврын хэрэгжилтэд нотлогдохуйц баримт, судалгаанд суурилсан, үндэслэлтэй, үнэн зөв, алдаагүй, ижил агуулгатай бусад тайлантай зөрүүгүй тоон үзүүлэлтийг тусган үйл ажиллагааг шаардлага хангахуйц чанартай бүрэн тайлагнахад анхаарах,

3. Хяналт, шалгалтын байгууллагаас өгсөн зөвлөмж, актын хэрэгжилтийг мэдээлэхдээ тодорхой, тоо, чанарын үзүүлэлтээр тайлагнаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусган эрх бүхий албан тушаалтнаар хянуулж, баталгаажуулж, цахимаар тайлагнаж байгаа тохиолдолд цаасан дээр буулгаж архивлах,

4. Боловсролын хэлтэс, Цагдаагийн газар, Газар зохион байгуулалтын алба зэрэг бусад хэлтэс алба, зарим орон нутгийн өмчит газруудад гомдол нэмэгдсэнтэй холбогдуулан удаа дараа давтагдаж буй гомдолд онцгой анхаарч, байгууллагын шуурхай болон даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, таслан зогсоох үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжилтийн үр дүнг тооцон Засаг даргын Тамгын газарт тайлагнах,

5. Зөрчил зонхилон бүртгэгдсэн Цагдаагийн газар, Газар зохион байгуулалтын алба, Цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба, 1, 4, 8, 23 дугаар хороо зэрэг байгууллагуудын удирдах албан тушаалтнууд ирсэн өргөдлийг өдөрт нь багтаан хүлээн авч шилжүүлэх, албан хаагчид өдөрт нь багтаан хүлээн авч, танилцан явцын тэмдэглэл хөтөлж хэвших нь зүйтэй.

6. Монгол Улсын Засгийн газрын shilien.gov.mn цахим хуудаснаас өөрийн байгууллагын цахим хуудасны нээлттэй мэдээлэлд хийсэн үнэлгээтэй танилцаж, цаашид хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахад онцгой анхаарч ажиллах,

2. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ХҮРЭЭНД

7. Нийт байгууллагууд албан бичгийн явцын тэмдэглэл, шийдвэрлэлтийг тухай бүр алдалгүй хөтлөх, eDoc систем ашиглалтын болон стандартын нийтлэг алдаа, зөрчлийн талаар холбогдох байгууллагатай хамтран нийт албан хаагчдын дунд сургалт зохион байгуулж зөрчил гаргахгүй ажиллахад анхаарч хариуцлагажуулах,

8.Байгууллагын түүхчилсэн лавлахыг тухай бүр баяжуулж, үйл ажиллагааны явцад үүсэж хөтлөгдсөн тусгай төрлийн баримт (кино, гэрэл зураг, дүрс бичлэг, дуу авиа гэх мэт)-ыг архивд нөхөн бүрдүүлж, бүртгэл хөтлөх, ажлаас чөлөөлөгдөж буй албан хаагчид Нийслэлийн Засаг даргын 2015 оны Захирамжаар батлагдсан А/633 актаар ажлаа хүлээлцэж хэвших,

9.Дотоодод архивын баримт ашиглуулсан бүртгэлийг журмын дагуу хөтөлж, БНШК-ын төлөвлөгөө, тайланг холбогдох журмын дагуу боловсруулж, архивлах,

10.Архивын Улсын үзлэг болон урьдчилсан үзлэгийн ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан, төлөвлөгөөний биелэлтийг тухай бүр тайлагнаж зөрчил дутагдлыг давтахгүй байхад анхаарч ажиллах нь чухал байна.

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ 3.БУЯНТ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ 4.МӨНХГЭРЭЛ

ТАЙЛАН БИЧСЭН:
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ
ХАРИУЦСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
МЭРГЭЖИЛТЭН Н.АЛДАРМАА